



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Бүрхээр

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Бүрхээр багт “Могойн гол” ХК-ийн байранд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цаг 20 минутад эхэллээ.

Хуралд нийт 829622 /Найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин хоёр ширхэг хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигч оролцохоос саналын эрх бүхий энгийн хувьцааны 722656 ширхэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, ирц 87,1%-тай байгаа нь Компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.4 дэх заалтыг хангасан учир Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай танилцуулав. /Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд: Хувьцаа эзэмшигч

№	Овог нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо
1	Орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Төмөрхуяг	РЛ85013016	423107
2	“Транс нефт” ХХК-ийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н. Батдорж	204660399777	124444
3	Ж. Батболд	ТЕ64010314	135451
4	Л. Батдэлгэр	ЙТ54081510	23067
5	Ч. Гүнсэнноров	ЙТ60021503	15098
6	Н. Батдорж	МЭ64102919	178
7	Т. Бат-Очир	РС62112614	1311
Хуралд оролцсон нийт дүн			722656

Хурлын дарга: Б. Должинсорогдог

Тооллогын комиссын дарга: Л. Шинэцэцэг

Тооллогын комиссын гишүүн: С. Даш

Тооллогын комиссын гишүүн: Т. Бат-Очир

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга: С. Мөнх-Эрдэнэ

Компанийн гүйцэтгэх захирал Л. Батхүү

Компанийн ерөнхий нягтлан Эрдэнэчимэг нар оролцов.

Хурлын дарга хурлыг нээж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон хурлын дэг, хуралд хүрэлцэн ирсэн орон нутгийн өмчийн төлөөлөл, хувьцаа эзэмшигчдийг танилцуулж, хурлыг нээв.

Сонссон нь:

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Тооллогын комиссын дарга Л. Шинэцэцэг та ирцийн мэдээллийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Л. Шинэцэцэг:

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий энгийн хувьцааны 722656 ширхэг буюу нийт хувьцааны 87,1 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцож байна. Энэ нь "Компанийн тухай хууль"-ийн 69 дүгээр зүйлийн 69.4 дүгээр хэсэгт заасан шаардлагыг хангаж байна.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

-Өнөөдрийн хурлаар

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудит хийгдсэн санхүүгийн тайланг дүгнэх тухай
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг дүгнэх, 2024 оны зардлын төсвийг батлах тухай
3. Компанийн ногдол ашиг хуваарилах талаар гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх
4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцэнэ.

Хурлын дэгийг танилцуулъя.

Хурлын ирц бүртгэх – 14.00-14.05

Хурлын ирц мэдээлэх – 14.05-14.10

Хурлын дарга хурал нээж хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах- 14.10-14.20

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт танилцуулах – 14.25-14.50

Асуулт хариулт, санал дүгнэлт- 14.50-15.00

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны тайлан танилцуулах- 15.00-15.20

Асуулт, хариулт, санал дүгнэлт- 15.20-15.25

Санал хураалт (Тогтоолын төсөл -1) – 15.25-15.35

ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийн гүйцэтгэл, 2024 оны зардлын төсөв батлах тухай тогтоолын төсөл танилцуулах- 15.35-15.50

Асуулт, хариулт, санал, дүгнэлт – 15.50-16.00

Санал хураалт (Тогтоолын төсөл -2) – 16.00-16.05

2023 оны ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг мэдээлэх, тогтоолын төсөл танилцуулах – 16.05-16.20

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай, тогтоолын төсөл танилцуулах – 16.20-16.30

Асуулт, хариулт, санал дүгнэлт- 16.30-16.40

Санал хураалт (Тогтоолын төсөл -3) – 16.40-16.50

Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах 16.50-17.00

Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах – 10 минут

Хурлыг хаах гэсэн хуралдааны дэг байна. Дэгээ батлах уу?

Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар дэг батлагдав.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчидээ!

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн оролцоотой “Могойн гол” хувьцаат компани нь байгуулагдаад 54 дахь жилээ үдэж байна.

Манай компанийн үе үеийн уурхайчид, бүтээлч хамт олон өнгөрсөн 54 жилийн хугацаанд нийт 2,7 сая тонн нүүрс олборлон Хөвсгөл, Завхан аймгийн эрчим хүчний байгууллагууд болон бусад хэрэглэгчдэд өндөр чанарын коксжих нүүрс нийлүүлсэн байна.

Тус компани нь Монгол улсын “Компанийн тухай хууль” болон олон улсын хэмжээнд мөрдөж буй “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, ашигт ажиллагааны түвшинг жил тутам нэмэгдүүлж ирлээ.

Өнөөдрийн байдлаар манай компанийн хувьцааг 1000 орчим хувьцаа эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж 52 брокер диллерийн компаниар дамжуулан эзэмшиж байна. Үүнээс манай компанийн хувьцаа эзэмшигч дэлхийн 13 орны гадаадын иргэн байгаа нь тус компанийн үйл ажиллагаа цаашид өргөжин тэлж, үр өгөөж нь өсөн нэмэгдэх тодорхой итгэл найдварыг та бидэнд хүлээлгэсэн хүндтэй үүрэг юм.

Сүүлийн жилүүдэд “Могойн гол” ХК-ийн үйл ажиллагаа нь бүх талуудын санаачлага, дэмжлэгээр тодорхой хэмжээнд өсөн дээшилж, эдийн засгийн үр ашиг нэмэгдсэнийг цохон тэмдэглэж, 2020-2023 оны эдийн засгийн үзүүлэлтийг компанийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлангаар харуулж байна.

Цаашид компанийн өмнө тулгамдсан олон асуудлыг оновчтой шийдвэрлэж, Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засагт болон нийт хувьцаа эзэмшигчдэд хүртээх үр өгөөжийг улам нэмэгдүүлэх томоохон зорилтыг дэвшүүлэн ажиллах болно.

Энэхүү зорилт нь Монгол улсын Засгийн газраас баримталж буй бодлоготой бүрэн нийцэх бөгөөд хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэн, компанийн засаглалыг сайжруулж, аймаг, сум орон нутагт эерэг нөлөөлөл бүрдүүлэх олон давуу талыг бий болгоно.

Хувьцаа эзэмшигчид та бүхэн компанийнхаа өнөөгийн байдалд бодитой дүгнэлт хийж, хэлэлцэж буй асуудлуудад анхаарлаа хандуулан, компанийн гүйцэтгэх удирдлагын багаас дэвшүүлсэн зорилт, санал санаачлагыг дэмжин, "Компанийн тухай хууль"-ийн хүрээнд оновчтой шийдвэрийг гарган, хөгжил дэвшилд хамтдаа хүрэхийг уриалж байна.

- Одоо та бүхэнд "Орон нутгийн өмчийн төлөөлөгч томилох тухай" аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн XXVI/13 дугаар тогтоолыг танилцуулъя.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XXVI хурлаас тогтоох нь:

1. Хөвсгөл аймгийн өмчийн оролцоотой "Могойн гол" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр Н. Төмөрхуягийг томилсугай. Үүнд:
 - а. Н. Төмөрхуяг – (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) компанийн нийт хувьцааны орон нутгийн өмчид ногдох 423,107 ширхэг энгийн хувьцааг төлөөлж санал өгөх
2. Орон нутгийн өмчийн төлөөлөгчийн хэрэгжүүлэх эрх хэмжээ, ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх албан тушаалтнуудыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

Дарга Г. Мөнгөнхуяг гэжээ.

Мөн Транснефт компанийн төлөөлөгчийн итгэмжлийг уншиж танилцуулъя.

Итгэмжлэх, Свердловск мужийн Екатеринбург хот 2024 оны 04-р сарын 07.

Миний бие, Романовская Светлана Александровна "Транс-Нефть" Хаалттай Хувьцаат Нийгэмлэгийн ерөнхий захирал, 1967 оны 04-р сарын 30-нд төрсөн, ОХУ, Екатеринбург хотын Верх-Исетский дүүргийн Цагдаагийн хэлтсээс 2004 оны 05-р сарын 31-нд олгосон № 6505114947 тоот паспорттой, Екатеринбург хотын, 8 Мартагийн гудамж, 1-р байрны №5 тоот хаягаар бүртгэлтэй. Энэхүү итгэмжлэлээр Монгол улсын иргэн Найдангийн Батдоржийг (регистрийн дугаар МЭ 64102919,

Монгол улс, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар хот, 6-р баг, Орхоны 2-р хэсэг гудамж, 9-р байр, №20 тоот хаягаар бүртгэлтэй) миний нэрийн өмнөөс дараахь үйл ажиллагаанд оролцон төлөөлж байх, мөн доорхи эрхийг олгож байна.

- “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралдаануудад бүртгүүлэн, хуралд оролцох,
- Хурлаар хэлэлцэх бүх асуудалд миний эзэмшиж буй бүх хувьцааны тоо ширхэгээр санал өгөх,
- Хувьцаа эзэмшигчдэд өгөх мэдээлэлийг хүлээн авч танилцах,
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр, хэлэлцэх асуудлын талаарх санал хураалтын дүнгүүдтэй танилцах,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх,
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэр болон протокол зэрэг бусад баримт бичигт гарын үсэг зурах. Транс-Нефть компанийн ерөнхий захирал Романовская С.А. гэжээ.

За дарааллын дагуу эхний асуудлаа хэлэлцье.

Хэлэлцсэн нь:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудит хийгдсэн санхүүгийн тайланг дүгнэх тухай

Сонссон нь:

Компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч Б. Батхүү:

-Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлангаа танилцуулъя аа.

Миний бие гүйцэтгэх захирал Батхүү, дэд захирал Хүчитбаатар, ерөнхий нягтлан бодогч Эрдэнэчимэг, эдийн засагч Шинэцэцэг гэсэн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй та бүхэнд танилцуулгаа хийх гэж байна.

За та бүхэн зураг дээрээс харж байгаа байх, манайх нүүрсээ гаргахын тулд өмнөх жилүүдээс илүү зузаан хөрс хуулах шаардлагатай болсон, тонсг төхөөрөмжүүдийн хувьд нилээн өндөр насжилттай, үндсэн техник болох өрмийн машин бол одоо үндсэндээ үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон байгаа, ТУЗ-ийн шийдвэрээр шинэ өрмийн машин авахаар болсон хөөцөлдөж байгаа, 2 экскаватор байдгийн нэгийг нь засварын багш авч ирж засуулж байна, нөгөөхийг нь Улаанбаатар хот руу

засварт явуулсан, бусад техникийн хувьд ажилд гарахад бэлэн байгаа. Компанийн экскаваторыг засварлаж дуустал маргааш буюу 5 дугаар сарын 01-ээс эхлэн "Эмералд Энд Спаркле" компанийн экскаватороор өнгөн хөрсөн дээрээ хөрс хуулалтын ажлыг эхлүүлж байхаар болсон.

Манай 2 экскаватор 5 дугаар сарын сүүлээр ажилдаа ороод 6 дугаар сарын 1-ний өдрөөс манай техникүүд ажиллаад эхлэнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Та бүхэн графикаас уурхай ажиллаж эхлэсэн цагаас хойших хөрс хуулалт, олборлосон бүтээгдэхүүний мэдээллийг харж байна.

Эндээс юу хэлэх гээд байна вэ? гэхээр жил ирэх тусам манай хөрс хуулалтын ажил нэмэгдэж байгаа. Өнгөрсөн 2023 онд манай компани өөрийн хүчин чадлаар болон туслан гүйцэтгэгч компанитай хамтран 1,249,000 метр куб хүрс хуулалт хийсэн.

Манай компани 743270 метр.куб, туслан гүйцэтгэгч 2 компани 506632 метр.куб хөрс хуулалт хийсэн. Энэ нь "Эмералд Энд Спаркле" ба Туалсе компаниуд.

Өнгөрсөн онд 5-12 сарын хугацаанд хөрс хуулалт хийгдсэн. 5-8 дугаар сар хүртэл техникийн түрээс байдлаар яваад 8 дугаар сараас тендэр зарлаж, 10 дугаар сараас гэрээ байгуулан ажиллуулсан.

Тендэрийг 800,000 м.куб, 500,000 м.куб, 400,000 м.куб-ээр гурав багцалж зарласан. Нийт 1,700, 000 м.куб хөрс хуулахаар зарлсан.

Эхний 2 багцад "Эмералд Энд Спаркле" оролцож 2023 оны 9 дүгээр сарын 15-нд эхний гэрээ, 2023 оны 11 дүгээр сарын 15-нд хоёр дахь гэрээгээ байгуулсан. Хамгийн сүүлийн 400,000 м.куб-ын багц дээр 3 удаа тендэр зарласны эцэст Туалсе компанитай 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулсан.

Энэ компаниуд маань ажлаа бүрэн хийж амжаагүй учраас манай 2023 оны хөрс хуулалтын ажил 50%-тай хийгдсэн.

Та бүхэн эндээс хөрс хуулалтын ажлын гүйцэтгэлийг дэлгэрүүлж харна уу.

Нүүрсний борлуулалтын хувьд 2023 онд 146,6 мян.тонн нүүрс борлуулсан. Оны эхэнд нилээн их коксжих нүүрс борлуулсан, оны төгсгөлд хөрс хуулалтын ажил удааширсан учир борлуулалт буурсан. Гэвч нийт дүнгээрээ 146,6 мян.тонн нүүрс борлуулсан нь өмнөх оноос ахисан.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд 8 тэрбум 850 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 8 тэрбум төгрөгийн зардал гаргасан. 795,815,000 ашиг гарсан бөгөөд үүнээс цэвэр ашиг 665,657,700 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

Улсад тэрбум гаруй төгрөгийн татвар төлж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсан.

2024 онд бид яах вэ?

Уулын ажлын төлөвлөгөө батлагдсан. 3,219,419 м.куб хөрс хуулж, 250100 тонн нүүрс олборлоно. Энэхүү ажлыг гүйцэтгийн тулд ТУЗ-аар шийдвэр гаргасан. 2,1 сая м. Куб хөрсийг тендэр зарлаж бусдаар гүйцэтгүүлнэ. Энэ жил өнгөрсөн өвлийн гаргасан алдаагаа давтахгүй, ажлыг эрт эхлүүлж байгаа.

За анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

- За компанийн мэдээлэлтэй танилцлаа. Асуулттай хувьцаа эзэмшигч байна уу?

Оролцогчид: Байхгүй

Саналтай хувьцаа эзэмшигч байна уу?

Оролцогчид: Байхгүй

Б. Должинсорогдог (хурлын дарга):

-За тэгвэл дараагийн асуудал руугаа оръё.

Хэлэлцсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг дүгнэх, 2024 оны зардлын төсвийг батлах тухай

Б. Должинсорогдог (хурлын дарга):

-Энэ асуудлыг би өөрөө оруулна.

2023 онд ТУЗ-д 332,252,000 төгрөг төсөвлөгдсөн. Гүйцэтэгл 255,890,900, 2024 оны зардлыг 2024 оныхоос нэмэгдүүлж орж ирж байгаа. Үүнд ТУЗ-ийн гишүүдийн урамшууллыг 2,5 сая, нарийн бичгийн цалинг 2,2 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн. ТУЗ-ийн 2024 оны нийт төсвийг 485,914,000 төгрөг байхаар оруулж ирж байна.

Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу?

Н. Төмөрхуяг:

-Бусад зардлуудтай санал нийлж байна, албан томилолтын зардал өмнөх оноос буурсан байна? Засгийн газрын тогтоолоор албан томилолт нэмэгдсэн. Зүгээр үү?

Эдийн засагч Л. Шинэцэцэг: Нийлбэр дүнгээр буураагүй, буудал, хоолны зардлаар нь задалж оруулсан байгаа.

Гүйцэтгэх захирал Б. Батхүү: Манай томилолт 50, 000, аймагт 25,000, суманд 10, 000 төгрөгийн тарифтай байснаараа үргэлжилт байгаа. Энэ жил Жавхлан сайдын гаргасан жишиг рүү хүргэхээр ярилцаж байгаа. Үүнийг бид компани дээрээ ярилцана. ТУЗ-ийн томилолтын хувьд нарийвчилж оруулсан, өмнөх оноос бууруулаагүй.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Өөр асуулт, санал байхгүй бол дараагийн асуудал руугаа орёё.

Хэлэлцсэн нь: Компанийн ногдол ашиг хуваарилах талаар гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх

-Батхүү захирал та мэдээллээ оруулах уу?

-Гүйцэтгэх захирал Б. Батхүү:

Өмнөх ТУЗ-ийн хурлаар шийдвэр гарсан, нэгж хувьцаанд 600 төгрөг тараахаар болсон. Нийт 497 000 000 төгрөг тараагдана.

Тарааж амжаагүй байгаа, санхүүгийн боломж бүрдэнгүүт нэн даруй тараагдана.

Ж. Батболд: Компанийн гол үзүүлэлт ногдол ашиг тарааж буй байдлаар илэрдэг. Ногдол ашиг тараах үйл явцийг удаашралгүй анхаарах хэрэгтэй.

Н. Батдорж: Ногдол ашиг хагас жилдээ багтах уу?

-Гүйцэтгэх захирал Б. Батхүү:

-Хагас жилдээ багтана. Биржийн тухай хууль гарсантай холбоотой экспортын нүүрсээ борлуулах ажил удааширч, компанийн санхүүд хүндрэл үүсгэж байна.

Өмнө нь өдийд дансандаа 4, 5 тэрбум төгрөгтэй байдаг байсан, энэ жилийн хувьд хүндрэлтэй байна.

Одоогоор 3 тэрбумын өглөгтэй байгаа. Хүндрэл асар их байгаа, гэвч энэ хүндрэлийг давах арга замаа олсон, ирэх 7 хоногт Улаанбаатар явж хөөцөлдөнө.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Өөр асуулт, санал байхгүй бол дараагийн асуудал руугаа оръё.

Хэлэлцсэн нь:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Сонссон нь:

Нэр дэвшүүлэх хорооны дарга Ж. Батболд:

Хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэсэн.

2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 18 цаг хүртэл материал хүлээн авсан.

Нэр дэвшүүлэх хорооны 5 гишүүний 3 нь танхимаар, 2 нь зайнаас онлайн хэлбэрээр оролцож асуудлыг МУ-ын ЗГ-аас баталсан ТӨК-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам, Компанийн тухай хууль, зар дээрх шалгуурын дагуу ажиллалаа. ТУЗ-ийн нарийн бичиг, гүйцэтгэх захирал хамт байж и-мэйлээр ирүүлсэн материалуудыг хэвлэж, жагсаалтын хамт гаргаж өгсөн. Нийт 5 хүний материал ирсэн. 3 хүн хугацаандаа, 2 хүн хугацаа хоцруулж ирүүлсэн.

Бид хэлэлцээд Н. Нэргүй, Б. Түмэндэлгэр, Г. Бат-Оргил нарыг дэвшүүлэхээр тогтоолоо гарган хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсанд бичиж хүргүүлсэн.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Нэр дэвшүүлэхтэй холбоотой асуулт, саналтай гишүүн байна уу?

Н. Төмөрхуяг: Миний хувьд 1 минут материалаа хоцроосон Амартүвшинг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх саналтай байна. Дөрвөн хүнийг хамтад нь

хэлэлцье. Цогтоо гуайн хувьд өнөөдөр материал ирсэн хэлэлцэх боломжгүй, Амартүвшингийн хувьд илгээсэн цаг нь 17.59 байгаа, ирсэн цаг нь 18.01 минут байгаа.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Өөр асуулт, санал байна уу?

Ж. Батболд: Хугацаа барихгүй бол Цогтоо хүртэл барьцана. Ийм учраас хугацаа хоцруулсан 2 хүнийг аль алиныг нь хассан нь зөв байх.

ЗГ-аас гаргасан журам дээр тогтоосон хугацаанд ирүүлэх гэж заасан байгаа. Нэр дэвшүүлэх хороон дээр хараат бусад Н. Нэргүй, Б. Түмэндэлгэр нар өөрсдөө нэр дэвшиж буй учир санал өгөхгүй түтгэлзсэн, Байлхүү, Төмөрхуяг болон миний бие гэсэн 3 хүн санал хураагаад Байлхүү бид 2 хасах нь зүйтэй гэж олонхоороо шийдсэн. Нэгэнт нэр дэвшүүлэх хороон дээр ярилцаад шийдсэн учир хугацаандаа материалаа ирүүлсэн иргэдийг дэвшүүлээд явах саналтай байна.

Би Амартүвшин, Цогтоо нарт өөрийн гарын үсэгтэй хариу бичиг хүргүүлнэ.

Ч. Гүнсэnnоров: -Амартүвшин 1 минутаар хоцроосон байна, хэдийгээр дүрэм, журам байгаа ч би энэ хүнийг нэр дэвшүүлээд явах саналтай байна.

Ж. Батболд:

-Гүнсэnnоровоо нэр дэвшүүлэх хороо компанийн хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу ажиллаад оруулж ирсэн, одоо оруулж болохгүй шүү дээ.

Ч. Гүнсэnnоров: -За ойлголоо. Цаашдаа залуу улсууд хариуцлагатай байж, хугацаандаа материал юмаа өгч байх хэрэгтэй юм байна.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Өөр асуулт, санал байна уу?

-За байхгүй бол хэлэлцэх асуудлаа хаагаад санал хураалтын ажил руугаа оръё.

Тооллогын комисс ажилдаа ороорой.

Тооллогын комиссын дарга Л. Шинэцэцэг:

-Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүнг танилцуулъя.

Ердийн гишүүнд:

Ж. Батболд – 599098 ширхэг санал

Н. Батдорж - 599098 ширхэг санал

Л. Батдэлгэр - 599098 ширхэг санал

Б. Должинсорогдог - 846214 ширхэг санал

Э. Улам-Өсөх - 846214 ширхэг санал

Б. Сумъяабат - 846214 ширхэг санал

Хараат бус гишүүнд

Г. Бат-Оргил – 1269321 ширхэг санал

Н. Нэргүй – 451292 ширхэг санал

Б. Түмэндэлгэр – 447355 ширхэг санал авч тус тус дэмжигдсэн байна.

-Өнөөдрийн хурлаар хэлэлцэгдсэн 1, 2 дугаар асуудлыг хуралд ороцсон хувьцаа эзэмшигчид бүгд 100% дэмжсэн, 3 дахь асуудал дээр сонссон, зүйтэй гэсэн санал өгсөн байна.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурал хэлэлцэх асуудлаа амжилттай хэлэлцэж дууслаа.

Санал хэлэх хувьцаа эзэмшигч байна уу?

Л. Батдэлгэр:

Хувь нийлүүлэгчдийн хурлаараа 2023 оны ажлаа хэлэлцээд дүгнэлтээ гаргалаа. Би цаашид ТУЗ болон компанийн гүйцэтгэх удирдлагад хандаж цөөхөн хэдэн зүйл хэлье.

1. Төлөөлөн удирдах зөвлөл орон тооны нарийн бичиг суурин ажиллах боллоо. Иймд ТУЗ-ийн хурлыг тогтмолжуулмаар байна. Компанийн зүгээс хурлаар

хэлэлцүүлэх асуудлынхаа материалыг авсаныхаа дараа ТУЗ-ын даргадаа танилцуулж хурлаа хийж байя.

2. Цаашид шинэ ТУЗ хуралдаж дарга, цэргээ батлаад явах байх. Энэ хурал дээр ТУЗ-ийн хурлын төлөвлөлтөө хийгээд оруулаад ирмээр байна. Жишээ нь 6 сард өвлийн бэлтгэл хангах, 9 дүгээр сард биелэлт нь ямар байгаа гэх мэт. Ийм ийм асуудлаар компанийн удирдлагуудаас ийм ийм мэдээлэл авъя гээд төлөвлөчихмөөр байна.
3. Компани зөвхөн ТУЗ-ийг хүлээх бус хэлэлцүүлэх шаардлагатай асуудлынхаа материалыг бэлтгэж нарийн бичигтээ 3 хоногийн өмнө өгөөд асуудлаа ТУЗ руу оруулж ирээд явах бүрэн боломжтой.

Компанийн хувьд:

Гол нь аливаа асуудалд удаашралтай хандаад байна. Жишээ нь өнөөдрийн байдлаар хөрс хуулалтын ажил жигдэрч эхэлж чадаагүй байна, зуны сар 6 биш шүү дээ. 9 сарын 15-нд Хөвсгөл, Завхан аймгийн галлагаа эхлэхэд нүүрс бэлэн байх ёстой.

Байнга ярьдаг юмнуудаа цаашдаа хэвшүүлнэ ээ. Мөнх-Эрдэнэ нарийн бичиг сайн тэмдэглээд аваарай.

11 сар гэхэд "Могойн гол" ХК-ийн 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хэлэлцэнэ. 12 сард энэ хүмүүс бидний гаргасан чиглэл дээр уулын ажлын төлөвлөлтөө хийнэ. 1 сарын 15 гэхэд бизнес төлөвлөгөө орж ирнэ. Ингэж төлөвлөлтөө сайжруулснаар бидний ажил урагшлах нэг алхам болно.

Тендэр зарлах асуудал гэхэд саяхан хурлаар орсон. Цаашдаа бид нэг сард нь тендэрийн асуудлыг нь хэлэлцчихдэг, 2 сард компани тендэрээ зарлачихдаг, 3 сард худалдан авал хийгдээд 4 дүгээр сар гэхэд ажил нь жигдэрчихсэн байдаг л баймаар байна.

Ийм нөхцөл боломжуудыг харахгүй бол биднийг өвөл хүлээхгүй шүү.

Одоо 2 экскаватор засвартай байгаа, 520 сарын дараа ирнэ, хөрс хуулалтын ажил 2 экскаватор явахад тээвэрлэх машинаа яах уу? Бидэнд байгаа машин 1 экскаваторын ажилд явах л машин байна.

Тийм учраас тээврийн асуудлаа ч урьдчилж хармаар байна.

Цаашдаа шинээр байгуулагдсан ТУЗ боломжийнхоо хирээр та бүхнийгээ дэмжин ажиллана.

Б. Должинсорогдог (хурлын дарга):

Л. Батдэлгэр хувьцаа эзэмшигч үнэтэй санал, зөвлөгөө өглөө.

Компанийн тухай хуулиар ТУЗ сардаа 1 удаа хуралдах ёстой. Өнгөрсөн жил 10 удаагийн хурал зарлагдаж 8 удаа хуралдсан байна.

Өмнөх 2 удаагийн хурлаар компанийн бизнес төлөвлөгөө батлах, худалдан авах ажиллагаа, бүтэц орон тооны асуудлууд орсон. Тэр үеэр компанийн эдийн засагч, ерөнхий нягтлан байгаагүй. Цаашдаа компанийн санхүү, үйл ажиллагаа хэлэлцэж байх үед эдийн засагч, нягтлан заавал оролцдог, асуудлаа ярьдаг баймаар байна.

Эцсийн дүндээ компани ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон Хөвсгөл ард түмэнд үр ашгаа өгдөг байх шаардлагатай.

Энэ жил шаардлагатай үедээ хурлаа хийгээд улирал бүр биелэлтийг нь тооцоод ажиллана гэж бодож байгаа.

Энэ жил хөрс хуулалтаа гайгүй хийчихвэл компани ашигтай ажиллах боломж байгаа, цаашдаа ажлаа сайжруулах тал дээр тал талдаа анхааръя.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа.

Хурлын үйл ажиллагаа хаасныг мэдэгдье.

Гүйцэтгэх захирал Б. Батхүү:

-Гүйцэтгэх удирдлагын зүгээс нилээдгүй том үүрэг, амлалт авсан байгаа. Цаашдаа ТУЗ-өөрөө олон шийдвэрүүд гаргуулах шаардлагатай болно.

Түрүүн ярьсан санхүүгийн хүндрэлүүдийг давж гарах асуудал дээр анхаарна. Энэ жил хөрс хуулалтаа амжилттай хийгээд нүүрсээ гаргаж чадах юм бол ирэх жил өөр болчихно. Компанийн хүн бүр хичээж ажиллана. Та бүхэн биднийг дэмжиж үр дүнтэй шийдвэрүүдийг тухай бүрт гаргаж өгөөрэй гэж хүсье. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурал 17 цаг 20 минутад дуусав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудит хийгдсэн санхүүгийн тайланг хэлэлцээд

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг дүгнэх, 2024 оны зардлын төсвийг батлах тухай ТУЗ-ийн дүнэлтийг хувцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ногдол ашиг тараахаар шийдвэрлэснийг 100%-ийн саналаар зүйтэй гэж үзэв.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааг 100%-ийн саналаар хангалттай гэж дүгнэв.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд:
 - Ж. Батболд (599098 ширхэг санал)
 - Н. Батдорж (599098 ширхэг санал)
 - Л. Батдэлгэр (599098 ширхэг санал)
 - Б. Должинсорогдог (846214 ширхэг санал)
 - Э. Улам-Өсөх (846214 ширхэг санал)
 - Б. Сумъяабат (846214 ширхэг санал)
 Хараат бус гишүүнд:
 - Г. Бат-Оргил (1269321 ширхэг санал)
 - Н. Нэргүй (451292 ширхэг санал)
 - Б. Түмэндэлгэр (447355 ширхэг) нарыг дэмжиж батлав.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Б.ДОЛЖИНСОРОГДОГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С. МӨНХ-ЭРДЭНЭ